



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/152

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 4 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 11 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Оросын Холбооны улсаас хүмүүнлэгийн тусламжаар ирсэн улаан буудайнаас Хөвсгөл аймагт хуваарилагдсан 200 тн, улаан буудайг савлахтай холбоотой зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлын 6,660,000 (Зургаан сая зургаан зуун жаран мянга) төгрөгийн зардлыг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.


3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дугаар сарын 05-ны өдрийн 04 дугаар
захирамжийн хавсралт



ГАМШГИЙН ЭРСДЭЛ БУУРУУЛАХ ЗАРДЛААС
ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Бараа материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт өртөг
1	Шуудай	5600	450	2520000
2	Уутны ам боох чансаа	4	35000	140000
3	Ажиллах хүмүүсийн хоолны зардал	200	20000	4000000
	Нийт			6.660.000

-----oOo-----